



ҮАГазрын харъяа Баян-Өлгий аймаг дахь Аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зоноозын өвчин судлалын төв
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон
жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/98/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: bayan_ulgii@mta.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 89838414 Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах



ЗОНООЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА С АЛТЫНАЙ ТАНАА

ҮНДСЭНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАЯРЬА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
83128 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 70422954, 70422930
E-mail: bayanoli@bayanoli.gov.mn

№ 405/2016 -ны № 1

Аудитын гэрчилгээ

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 16.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Баян-Өлгий аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг хэлбэрдэх хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөөлж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, өмнөх гүйцэтгэний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлийг хангалттай цуглуулсан.

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой дараах зөрчилүүд нь Оршин байж, Тохимолдоон байж, Иж бүрэн

Tatgalzah sand dugnelt-2.doc

Байж, Үнэлгээ, Хэмжээ, Тогилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Түүнд

1. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлд өмнөх оны өглөгийг харуулаагүй оролгдуулсан. Жилийн эцсийн өглөг, авлагын тооцоог нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан акт материал ирүүлээгүй.
2. Цэрэр, хөрөнгө, өөрийн өөрчлөлтийн тайлан болон Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүн, тайлант үеийн үр дүн нийтдээ 68273.5 мянган төгрөг, дахин үнэлгээний зөрүү 100468.6 мянган төгрөгийг салгаж харуулаагүй өмнөх үеийн үр дүнд бэлэн дүнгээр бичсэн.
3. Тайланд өнд жергөн худалдан аваагүй болсон Мөнгөн гүйцэтгэний тайланд жергөн оруулалтын мөнгөн гүйцэтгэг буруу нэхсэн.
4. Санхүүгийн тайлангийн аудитад тээвэр шатахууны зарцуулалт, жолоочийн тооцооны хуудас, аж ахуй бараа материалын тайлан, тооцоо, жергөний эхний эцсийн тооллого зэрэг баримтуудыг аудитад ирүүлээгүйгээс орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог тулган шалгах боломжгүй байна.

Бичлэг хийсэн аудит санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай бэлгэд, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Санал дүгнэлт өгөхөөс татгалзах

Дээрх алдаа, зөрчлийн улмаас Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйцэтгэ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, өмнөх гүйцэтгэнийг холбогдох хууль, УСНБСОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлээгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Tatgalzah sand dugnelt-2.doc

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Зоноозын өвчин судлалын төвийн дарга С.Алтынай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.13-наас 2017.02.17-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.17-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.25-нд төрийн аудитын байгууллагад 2017.01.20-ны өдрийн 11–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж– Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Зоноозын өвчин судлалын төв *“Байгалийн голомтот, зоноозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино”* эрхэм зорилгын дор Эрүүл мэндийн яамны эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Зоноозын өвчин судлалын төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Зоноозын өвчин судлалын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Зоноозын өвчин судлалын төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба аудитад баримт материалаа бүрэн ирүүлээгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан тул дахин хянах боломжгүй байна.

Тайлант онд Цагдаагийн газар, Прокурорын газраас нягтлан бодогчтой холбоотой санхүүгийн шалгалт хийгдсэн байна.

Зоноозын өвчин судлалын төвийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Зоноозын өвчин судлалын төвийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Аколоус” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Зоноозын өвчин судлалын төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл өндөр, 18 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 60 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг төлөвлөлтмйн сонгосон.

Тус Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт өгсөн тул гүйцэтгэлийн шатанд аудитлагдсан тайлан гараагүй, материаллаг түвшинг тооцох боломжгүй байна.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 19 эрсдэлтэй асуудалд 19 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 31 хувь буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	19	25.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	1	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		20	25,5	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн байгууллагын дарга С.Алтынайд сахилгын шийтгэл ногдуулах саналыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй байна.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2016 оны санхүүгийн тайланд Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт авсан тул дараа оны санхүүгийн тайлан гаргалтын асуудлыг анхаарах асуудалд оруулж байна .

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Тус төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар тодруулга оруулах боломжгүй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Зоноозын өвчин судлалын төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 21 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 21 горим сорил хэрэгжүүлэв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100,0% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Зооноозын өвчин судлалын төв 2016.06.06-ны өдрийн 18 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталж үзэх боломжгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зооноозын өвчин судлалын төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зооноосын өвчин судлалын төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлээгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их, дүгнэлт гаргахад суурилах аудитын хангалттай ба зохистой нотолгоо олж авах боломжгүй байгаа тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж үндэслэл болно гэж үзлээ.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Зоноосын өвчин судлалын төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1

Илрүүлэлт

Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлд өмнөх оны өглөгийг харуулаагүй орхигдуулсан, жилийн эцсийн өглөг, авлагын тооцоо нийлсэн акт материал ирүүлээгүй, Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан болон Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүн, тайлант үеийн үр дүн, дахин үнэлгээний зөрүүг салгаж харуулаагүй өмнөх үеийн үр дүнд бөөн дүнгээр бичсэн, Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг буруу нөхсөн. Санхүүгийн тайлангийн аудитад тээвэр шатахууны зарцуулалт, аж ахуй бараа материалын тайлан, тооцоо, хөрөнгийн жилийн эцсийн тооллого зэрэг баримтуудыг аудитад ирүүлээгүйгээс орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог тулган шалгах боломжгүй байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” 14.4.2.бүх хөрөнгө, авлага”, 14.4.3 “бүх өр төлбөр”, 14.4.6.бүх зардал” гэсэн заалтуудыг баримталж нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах, санхүүгийн тайланг үнэн зөв алдаагүй гаргаж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгуулах.

Хариуцах ажилтан

Дарга С.Алтынай, нягтлан бодогч
Е.Есенжол

Эрсдэл

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөр үнэн зөв бүртгэгдээгүй, тайлант үеийн зардал үнэн зөв тусгагдаагүй байх эрсдэлтэй /Оршин байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж ажиллахыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Зоноозын өвчин судлалын төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт өгөгдсөн тул аудитлагдсан санхүүгийн тайлан гараагүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Огноо: 2017.02.17

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР
Огноо: 2017.02.17

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2017.02.17